



“Экономиксийн цагаан толгойг хэн сайн мэдэх вэ?”

Улсын XIV олимпиадын II шатны удирдамж

Зорилго:

Эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр их, дээд сургуульд суралцдаг I түвшний оюутнуудын экономиксийн мэдлэг чадвар, авхаалж самбааг сорих, мэдээлэл солилцох, цаашид экономиксийг судлах сонирхлыг дэмжихэд оршино.

Оролцох оюутнууд:

Олимпиадын нэгдүгээр шатнаас шалгарсан нийт 8 баг оролцоно. Багийн бүрэлдэхүүнийг сольж өөрчилж болохгүй. Өөрчлөлт орсон тохиолдолд олимпиадад оруулахгүй. Багийн бүх гишүүд оюутны үнэмлэх эсвэл иргэний үнэмлэхээ авчирна.

Хамрах сэдэв:

- Микроэкономиксийн үндэс хичээлийн дараах сэдвүүд
 - Эдийн засгийн үндсэн зарчим
 - Эрэлт ба нийлүүлэлтийн хууль, мэдрэмж
 - Зах зээлийн тэнцвэр, татвар татаасны нөлөөлөл
 - Пүүсийн онол: үйлдвэрлэл ба зардал
 - Зах зээлийн хэлбэрүүд (төгс ба төгс бус өрсөлдөөнт зах зээл)
 - Хүчин зүйлсийн зах зээл
- Макроэкономиксийн үндэс хичээлийн дараах сэдвүүд
 - Үндэсний тооцооны систем
 - Нийт эрэлт, нийт нийлүүлэлтийн загвар
 - Нийт зарлагын загвар: Кейнсийн загвар
 - Эдийн засгийн хэлбэлзэл, бизнесийн мөчлөг
 - Сангийн бодлого
 - Мөнгө ба мөнгөний бодлого

Олимпиадын журам:

Олимпиадын 2-р шат 2018 оны 5 сарын 12-ны өрдийн Бямба гаригт 11.00 цагт МУИС дээр болно. Тус шатанд дараах тэмцээнүүд явагдана.

1. Багийн асуулт-хариултын тэмцээн
2. Бодлогын тэмцээн
3. Багийн ахлагч нарын асуулт-хариултын тэмцээн
4. Блиц асуулт-хариултын тэмцээн

Багийн асуулт-хариултын тэмцээн: Зохион байгуулах комиссын бэлтгэсэн асуултуудаас сугалж, өгөгдсөн хугацаанд багаараа зөвшилцөж хариулна. Бэлтгэх хугацаа 1 минут, хариулах хугацаа 2 минут байна.

Бодлогын тэмцээн: Зохион байгуулах комиссын бэлтгэсэн бодлогуудыг өгөгдсөн хугацаанд бодож гүйцэтгэнэ. Бодолтыг тайлбарлуулахгүйгээр шууд дүгнэнэ. Бодолт хийх хугацаа 10 минут, нийт 4 бодлого байна.

Багийн ахлагч нарын асуулт-хариултын тэмцээн: Зөвхөн багийн ахлагч нар асуултад өгөгдсөн хугацаанд багтаан хариулна. Бэлтгэх хугацаа 1 минут, хариулах хугацаа 2 минут байна.

Блиц асуулт-хариултын тэмцээн: Өгөгдсөн хугацаанд (2 минут) тавигдсан асуултуудад маш товч (1-3 үгээр) хариулна. Багийн бүх гишүүд оролцоно. Багийн эхний гишүүний өгсөн хариултыг багийн гэж хариулт гэж тооцно.

Шагнал:

Хоёрдугаар шатнаас шалгарсан эхний 3 баг шагналтай.

- 1-р байр 1: Өргөмжлөл, шилжин явах цом, 500,000 төгрөг
- 2-р байр 1: Өргөмжлөл, 400,000 төгрөг
- 3-р байр 1: Өргөмжлөл, 300,000 төгрөг

Жич:

2-р шатны тэмцээний нийлбэр оноо нь тэнцсэн тохиолдолд багийн ахлагчийн асуулт-хариултын тэмцээний оноогоор ялагчийг тодруулна. Багийн ахлагчийн асуулт-хариултын тэмцээний оноо тэнцсэн тохиолдолд багуудын I шатны оноог харгалзаж шийднэ.

Утас: 88168887, 88889900

Хаяг: МУИС-ийн хичээлийн V байр, 608 тоот

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНХИМ

2018 он